

14 хоногийн мэдээ

2021.08.06

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3,858,374,00 төгрөгийн санхүүжилтээр Хамтын хүч бүлгийн гудамжны гэрэлтүүлэгийн ажлын гүйцэтгэлийг 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр 6 хүний бүрэлдэхүүнтэй хүлээн авлаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 17,868,851,00 төгрөгийн санхүүжилтээр Хамтын хүч бүлгийн цамхагт гэрлийн ажлын гүйцэтгэлийг 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр 6 хүний бүрэлдэхүүнтэй хүлээн авлаа.

ОНХСангийн санхүүжилтээр Морьт багт гаргах 9,800,000 /Есэн сая найман зуун мянга /төгрөгөөр Эхний Эхэн иргэний бүлэгтэй гэрээ байгууллаа.

Говь-Угтаал сум, Дэрэн сумын нутаг дэвсгэрийн хилийн маргаантай байгаа газрууд, өвөлжөө, хаваржааны доорхи газруудын координатыг тогтоох ажлыг 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Сумын ИТХ-ын дарга С.Дугарбаатар, Засаг дарга Θ.Мөнх-Амгалан, газрын даамал Б.Хорол нарын бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа.

2021 оны 08 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд 366 өрхөөс 184 өрхийн ноосны урамшууллын материалыг хүлээн авч, Аймгийн хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ.

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн хэлтсээс 2021 оны 07 дугаар сард улаан загалмайгаас олгосон хүнсний дэмжлэгийг 4 иргэнд олголоо.

Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийг үндэслэн 3 иргэний гомдол мэдээллийг хүлээн авч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гарган прокурорын газарт хянуулахаар хүргүүллээ.

Хүүхдийн цэцэрлэгийн хамт олон байгууллагын гадна дотор орчны цэвэрлэгээг зохион байгуулж, байгууллагын ногоон байгууламжийг усалгааг зохион байгууллаа.

1. Голомтоонд 525 м², урьдчилан сэргийлж 129 м² нийт 654 м² газарт ариутгал халдвартгүйтэл хийгдсэн.
2. Улаанбаатар хотоос ирсэн болон ойрын хавьтлын 61 хүнд түргэвчилсэн оношлуураар шийнжилгээ хийсэн. Үүнээс эерэг 5, PCR оношлуураар 2 хүнд хийж 1 иргэн эерэг гарлаа.
3. Коронавируст халдвараар 5 иргэн 1 хүүхэд нийт 6 хүн батлагдсныг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж байна. Улаан бүсэд 1 их эмч, 1 сувилагч, 1 үйлчлэгч ажиллаж байна.
4. 12-17 насны хүүхэд, жирэмсэн, архаг хууч өвчтэй иргэний 1 ба 2 тунгийн вакциныг 17 хүнд, 2 сараас 2 настай 13 хүүхдэд товлолын вакциныг тус тус хийсэн.
5. Лаборторит Цусны ерөнхий шинжилгээ 12, Шээсний ерөнхий шинжилгээ 12, иммуннологи 5, биохими 7, Дох 4, тэмбүү 4, элэгний В, С вирус 3, нийт 47 иргэнд шинжилгээ хийсэн.

6. Байгууллагын гадна машин зогсоолын талбайд хайрга чулуу асган тарааж шавар тогтооос хамгаалсан.
7. Байгууллагын 2022 оны төсвийн төслийг Эрүүл мэндийн газарт хүргүүлэв.

МЭДЭЭ ХЯНАСАН

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГОХ

МЭДЭЭ ГАРГАСАН

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.МАНДАХЦАЦРАЛ